



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/264

Булган

### Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгагдсан Баяннуур сумын сургуулийн барилгын их засварын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан Булган аймгийн “Булган барилга” ХХК-тай 149 295 845 /нэг зуун дөчин есөн сая хоёр зуун ерэн таван мянга найман зуун дөчин тав/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Ү.Бямбасүрэн/-т олгосугай.


2. Гүйцэтгэгчтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Д.Буманбаяр/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Эрдэнэбаатар/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Ү.Бямбасүрэн/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Булган барилга” ХХК-ийн захирал /С.Сэр-Од/-д даалгасугай.

4. Гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаанд тус компанийн ирүүлсэн саналын дагуу орон нутгийн ажилгүй иргэдээс 10 хүн ажиллуулж буй эсэхэд хяналт тавихыг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга /Н.Батжаргал/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү ажлын санхүүжилтийг 2019 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Д.Батцогт/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

2019039

Аймгийн Засаг даргын 2019 оны 05 сарын  
10 өдрийн 4 дүгээр захирамжийн хавсралт  
664

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн
1	Зураг төсвийн үнэ	4 000 000
2	Магадлашгүй ажил	2 627 861
3	Техник хяналтын зардал	2 627 861
4	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	1 313 930
5	Орон нутгаас авах ажиллах хүчний тоо	10
6	Алданги	Хоногт гэрээний үнийн 0.2 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувь байна.
7	Ажил гүйцэтгэх хугацаа	56 хоног